



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 12 сарын 07 өдөр

Дугаар

А/533

Арвайхээр

**Буцалтгүй тусламж олгох тухай**

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, аймгийн Засаг даргын 2018 оны а/676 дугаар захирамжаар батлагдсан "Аймгийн Засаг даргаас нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж үзүүлэх журам"-ын 2.1, 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Уянга сумын иргэн, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар Паламхүүгийн Галсан-Ёндонг таалал төгссөнд эмгэнэл илэрхийлж, ар гэрийнхэнд нь 300,000 (гурван зуун мянга), галын аюулын улмаас орон гэр нь шатаж хохирол учирсан Арвайхээр сумын 4 дүгээр багийн иргэн Пүрэвийн Дондолсүрэнд 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийн буцалтгүй тусламж тус тус олгосугай.

2. Дээрх 1,800,000 (нэг сая найман зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101209